

**“ИРГЭН БҮР САНААЧЛАГЧ – ӨРХ БҮР ҮЙЛДВЭРЛЭГЧ”  
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Сайншанд

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
3.1. Олон нийтийн хэвлэл мэдээлэл болон бусад сурталчилгааны сувгаар амжилттай бизнесийн түүх, шилдэг туршлага, төрийн бодлогыг сурталчлан таниулах							
1		3.1.1. Дотоодын болон олон улсын бизнесийн боломжийг судлахад дэмжлэг үзүүлнэ.	2019 - 2022			<p>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөн буйр аймгийн Хайлаар хотод зохион байгуулагдсан "Ногоон хөгжил" олон улсын үзэсгэлэн яармагт тус аймгаас 5 хүний төлөөллийг хамруулж шинэ техник, технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулж хамтын түншлэлээ бэхжүүлэн ажилласан. Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Монгол ногоо" төслийн хүрээнд 5 тариалан эрхлэгчийг, "Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагын "Гамшигт тэсвэртэй орон нутаг" төсөлтэй хамтран Дэлгэрэх, Хөвсгөл, Эрдэнэ сумдын малчин, тариаланчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань сумын эрчимжсэн мал аж ахуй, ногоон тэжээл тариалалт, бордооны үйлдвэр, 4 улирлын хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, жимс тариалалт, мод үржүүлэг, хүнсний үйлдвэрлэл, хоршоо зэрэг 9 чиглэлээр тус тус туршлага судлуулсан. Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв, "Инвест Ко-оп Монгол" төсөл-тэй хамтран "Тогтвортой хөгжил –залуу хоршоологчдын оролцоо" сэдэвт зүүн бүсийн залуу хоршоологчдын зөвлөгөөн Сүхбаатар аймгийн Дарьганга суманд зохион байгуулагдаж 3 /Иххэт, Сайхандулаан, Дэлгэрэх/ сумдын хоршоодын төлөөлөл 6 иргэнийг хамруулсан.</p> <p>Засгийн газрын 81 тогтоолоор 2022 оныг "Хоршоо хөгжлийг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Айраг, Улаанбадрах сумдын 2 хоршооны төлөөллийг Алтанширээ сумын "Олон ширээ" хоршооны үйл ажиллагаатай танилцуулсан. "Хоршоонд суурилсан ХАА-н тогтвортой хөгжил төсөл"-тэй хамтран орон нутагт хоршооны хөгжлийг дэмжих талаар хэрэгжүүлж буй дотоодын туршлага судлах, үзүүлэх сургалтад 3 хоршооны төлөөллийг хамруулсан. Дотоодын болон олон улсын бизнесийн боломжийг судлах, төрийн бодлогыг сурталчлан таниулах чиглэлээр 10 удаагийн томоохон сургалт, арга хэмжээнд газар тариалан эрхлэгч 150 иргэн, хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ эрхлэгч 125 иргэнд</p>	100%

					дэмжлэг үзүүлсэн.	
2	3.1.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж төрийн бодлогыг сурталчилна.	2019 - 2022			<p>Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, "Чадваржсан иргэн-Тогтворжсон амьжиргаа" төсөл, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран "Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал", Хоршооны бодлого чиглэл хоршооны үнэлгээг хэрхэн зохион байгуулах, "Жижиг дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах журам", "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл", "Санхүү татварын тайлангийн бүрдэл анхаарах зүйлс", "Бизнес төсөл төлөвлөгөө хэрхэн боловсруулах" "Албан ба албан бус бизнесийн ялгаа сургалт", "Бизнес загвар гэж юу вэ?", "Компанийн засаглалын тухай ойлголт", "Дотоод хяналтын ач холбогдол" "Цар тахлын үед бизнес загвараа тодорхойлох нь" "Бизнесийн эрсдэлийн удирдлага ба дотоод хяналт" чиглэлээр 5 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж давхардсан тоогоор 376 иргэн, аж ахуй нэгж хамрагдсан.</p> <p>"Бизнесийн салбарт хүний эрхийг хангах нь" төвийн бүсийн хэлэлцүүлгийг танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр зохион байгуулж 150 иргэнийг хамруулсан. "Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэл"-ийг батлан хэвлэл мэдээллийн хэрэгсэл (DTV), байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан 14864 иргэнд хүргэсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулагдсан 4 удаагийн "Үндэсний зөвлөгөөн, чуулган"-д орон нутгийн хүнс, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, малчдын 45 төлөөллийг хамруулсан. Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ сумдад "Хоршооны тухай ойлголт", "Хоршоо хөгжүүлэх сан"-гийн үйл ажиллагаатай холбоотой танхимын сургалтыг зохион байгуулж, 1002 иргэн, аж ахуйн нэгжид мэдээлэл хүргэсэн. "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Зээл ба санхүүгийн боломжууд" сэдэвт сургалтад Сайншанд сумын өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 43 иргэнийг хамруулж мэдээлэл өгч ажилласан.</p>	100%
3	3.1.3. Олон улсын болон дотоодын амжилттай бизнесийн түүх, шилдэг туршлагыг орон нутгийн хэвлэл мэдээллийн	2019 - 2022			<p>Орон нутагт сурталчлах таниулах ажлын хүрээнд агентлагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 34 иргэдэд "Монголд үйлдвэрлэв" каталог болон гарын авлага зөвлөмжийг тараасан. Мөн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Дорнын говийн залуусын нэгдэл Төрийн бус байгууллагатай хамтран "Бизнес эрхлэгчдийн форум зохион байгуулж нийт 350 гаруй бизнес эрхлэгчид хамрагдан үйл ажиллагаагаа танилцуулах, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэн, харилцан мэдээлэл солилцсон.</p> <p>"Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран "Цагаан сүүний буян" ХХК, "Органик савангийн үйлдвэр"-ийн үйл ажиллагааг сурталчлан нэвтрүүлэг бэлтгэн олон</p>	100%

		байгууллагатай хамтран олон нийтэд хүргэнэ.			нийтэд хүргэсэн. “Өрхийн хэрэгцээг өөрийн хашаанаас” хөдөлгөөн өрнүүлж, тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин үрийн багц олгосон ба үйл ажиллагааг сурталчлах, тэргүүн туршлагыг нийтэд түгээх, тогтмол үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, Ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар өрнүүлж буй "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд орон нутгийн хүнсний үйлдвэрлэл эрхлэгч зургаан аж ахуйн нэгж, тахианы аж ахуй эрхлэгч нэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг оролцуулсан зэрэг арга хэмжээг DTV телевизээр олон нийтэд сурталчилсан.	
4		3.1.4. Орон нутгийн шилдэг өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг шалгаруулж, урамшуулах ажлыг зохион байгуулна.	2019 - 2022		<p>Коронавирус цар тахлын онцгой нөхцөлтэй уялдуулан орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээлч санаачилгыг өрнүүлэх, сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор “Орон нутгийн онцлох бүтээгдэхүүн” шалгаруулах уралдаан болон ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн "Шилдэг ахуйн үйлчилгээ" шалгаруулах уралдааныг тус тус цахимаар зохион байгуулж 50 гаруй иргэн, аж ахуй нэгж оролцсоноос, шилдэг 5 байрыг шалгаруулж урамшуулсан.</p> <p>Орон нутгийн газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, нутгийн шилмэл үүлдрийн малыг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах “Намрын ногоон өдрүүд”, “Шилмэл мал” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, 14 сумын 358 иргэн, аж ахуйн нэгж, 50 гаруй малчин оролцож, 187,7 сая, төгрөгийн борлуулалтыг хийсэн бөгөөд 5 төрлөөр шилдгүүдээ шалгаруулсан. "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр -2022" арга хэмжээнд тус аймгийн "Онцлох аж ахуй нэгж" ээр шалгарсан "Далт мөнгөн шанд" ХХК-ийн "Загсгал цай", "Дорнын Үжин Гоо" ХХК-ийг эко саван, эсгий урлалын төрлөөр оролцуулахаар 1,0 сая төгрөгийн замын зардлын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p>	100%
3.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бараа, бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжих						
5		3.2.1. Орон нутагт хэрэгжиж буй үндэсний бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөр, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чанар	2019 - 2022		<p>Уул уурхайн болон томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нартай жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг холбох, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого барин, Алтанширээ сумын нутагт баригдаж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэгч талтай орон нутгаас хамтран ажиллах “Говь консалтинг менежмент” ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулсан. “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэгч “JMC Projects Mongolia” ХХК-тай орон нутгийн худалдааны 3, цэвэр усны 1, мах, махан бүтээгдэхүүн 1 аж ахуйн нэгж гэрээ байгуулан захиалгын дагуу нийлүүлэлт хийсэн.</p> <p>Үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцож буй туслан гүйцэтгэгч 8 компани нь</p>	100%

		стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүний нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэн хэрэглэгч, үйлдвэрлэгчийг холбоно.			цэвэр усны 4, мах 1, сүү, сүүн бүтээгдэхүүний 1, хүнсний ногооны 1 аж ахуйн нэгжтэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг Сайншанд сумын зах худалдааны төв, худалдаа, үйлчилгээний газруудаас сонгон авдаг. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 21 уурхай, боловсруулах болон баяжуулах 13 үйлдвэр, тээврийн 35 компани нь 14 сумын худалдааны 38, цэвэр усны 12, мах 1, махан бүтээгдэхүүний 1, сүү, сүүн бүтээгдэхүүний цех 1, фермер 6, өндөгний аж ахуй эрхлэгч 1, оёдлын үйлдвэр 1, цех 18, ногооны 4 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээгээр, бусад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, сэлбэг, шатах, тослох материалыг тухай бүрд орон нутгийн бизнес эрхлэгчдээс худалдан авсан.	
6		3.2.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн зорилтот бүлэгт чиглэсэн хүний нөөцийн сургалтыг зохион байгуулна.	2019 - 2022		<p>Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэх боломжтой 4 мэргэжлээр зорилтот бүлгийн 64 иргэнийг сургаж, чадамжийн гэрчилгээ олгосон. Сургалтад хамрагдсан иргэдийн 42.6% нь нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай өрхийн гишүүд бөгөөд чадамжийн гэрчилгээтэй болсноор өрхийн болон жижиг үйлдвэрлэл эрхэлж, өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломжтой болсон.</p> <p>Аймгийн Политехникийн коллежийн сургалтаар хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн ангийг 7, оёдолчин 18, үсчин 21, гоо сайханч 2, хэвлэлийн графикч 17, бэлэг дурсгалын зүйл урлаач 9, тогооч 35, худалдагч 6, нийт 84 мэргэжилтэй ажилтан бэлтгэгдсэн.</p>	100%
7		3.2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүний тоо, нэр төрлийг нэмэгдүүлнэ.	2019 - 2022		<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 437 төсөл, арга хэмжээний 106,9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсаны дагуу тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, гэрээ байгуулсан. Улсын төсвөөс нийт 27,0 тэрбум төгрөгийн 5 төсөл арга хэмжээний захиалагчийн эрх шилжиж ирсэн. Үүнд: Соёлын яамнаас 16,5 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 9,8 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, Барилга хот байгуулалтын яамнаас 650,0 сая төгрөгийн /1 төсөл арга хэмжээ/, бусад эх үүсвэрээс санхүүжих 508.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ шилжин ирж нийт худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 44,7 тэрбум төгрөгийн 56 төсөл арга хэмжээ тусгагдаж төсвийн ерөнхийлөн захирагчаар төлөвлөгөөг батлуулсан.</p>	50%
8		3.2.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа,	2019 - 2022		<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 73 төсөл арга хэмжээг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтын дэлгэрэнгүй төлөвлөгөө цэсэд байршуулж Сангийн Яамаар батлуулсан. Тендер шалгаруулах урилгыг tender.gov.mn болон "Зууны мэдээ" өдөр тутмын сонинд байршуулан, шалгаруулалтыг 100 хувь</p>	100%

		бүтээгдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлана.			хялбаршуулсан цахим системээр зарлаж, үр дүнг тухай бүр тендерт оролцогчдод 100 хувь ил тод байлгасан.	
9		3.2.5. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэн гэрчилгээжүүлнэ.	2019 - 2022		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим,"Монгол брэнд" ХХК-тай хамтран орон нутагт нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг салбар тус бүрээр нь төрөлжүүлсэн мэдээллийн нэгдсэн бааз (онлайн платформ)-ыг үүсгэж гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчлах, орлуулалтыг нэмэгдүүлэх, иргэд, худалдан авагчид нэг дороос шаардлагатай мэдээллийг авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Уг ажлын хүрээнд <a href="http://www.mongolbrand.mn">http://www.mongolbrand.mn</a> цахим хуудсанд 6 аж ахуйн нэгжийн мэдээллийг оруулсан. Аймгийн засаг даргын захирамжаар батлагдсан "Цагаан сар-2019", "Намрын ногоон өдрүүд", үзэсгэлэн худалдаа жил бүр зохион байгуулагдаж 14 сумын иргэн, аж ахуй нэгж 400 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцон, 237 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэн гэрчилгээ олгож ажилласан.	100%
3.3. Орон нутгийн өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд мэдлэг, мэдээлэл олгох зөвлөх үйлчилгээг хөгжүүлнэ						
10		3.3.1.Мэдээллийн технологи, маркетинг, санхүү бүртгэл, хөрөнгө оруулалт, аюулгүй ажиллагааны чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.	2019 - 2022		Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас эрх авсан сургалтын байгууллагатай хамтран өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 137 иргэнд "Аж ахуй эрхлэлт болон зээлийн өмнөх сургалт буюу төсөл бичих, санхүүгийн тооцоолол хийх, бизнесээ хэрхэн хөгжүүлэх" чиглэлээр сургалтыг зохион байгуулсан бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2.6 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан. Сургалтад хамрагдсан 60 иргэнд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний тоо 28-аар, сургалтад хамрагдсан хүний тоо 21-ээр тус тус нэмэгдсэн .	100%
11		3.3.2. Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үйл ажиллагааг дэмжих,	2019 - 2022		Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн гарааны бизнесийг дэмжих Старт-ап арга хэмжээний сургалтад "Вест метод" ХХК-ын дэргэдэх сургалтын төвтэй хамтран 44 залууг хамруулан чадавхжуулж, сонгон шалгаруулалтаар 17 залууг менежментийн үйл ажиллагааг дэмжих, өрсөлдөх	100%

		өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, гарааны бизнесийг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.			чадварыг бэхжүүлэх, гарааны бизнесийг хөгжүүлэх хурдасгуур арга хэмжээнд 5 долоо хоногийн турш хамруулсан. Дээрх хугацаанд Дорноговь брэнд бүтээгдэхүүн, Baby and mommy yoga, Monkhi studio хувцас засварын 3 баг төслөө танилцуулж, шилдэг багаар М.Бодьханд ахлагчтай "Baby and mommy yoga" төсөл шалгарч 10.0 сая төгрөгийн батламжийг гардуулсан. Тус арга хэмжээний сургалтын зардалд 5.6 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. "Хөгжлийн шийдэл" төрийн бус байгууллагаас 2021, 2022 онд цаашид тогтвортой хөгжих боломжтой боловч санхүүжилт авах чадамжгүй 8 гарааны бизнес эрхлэгчид тус бүр 10,0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон. 2019-2022 онд 20 төсөлд 1,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Хөдөө аж ахуйг дэмжих 3%-н хүүтэй зээл болон "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 8 ААН, 4 иргэнд 449,3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлсэн.	
12		3.3.3. Орон нутгийн өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн техник, технологийн мэдлэгийг дээшлүүлэх, шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургууль, хувийн хэвшлийн уялдаа холбоо хангана.	2019 - 2022		Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв, "Инвест ко-оп монгол" төсөлтэй хамтран "Тогтвортой хөгжил –залуу хоршоологчдын оролцоо" сэдэвт зүүн бүсийн залуу хоршоологчдын зөвлөгөөн Сүхбаатар аймагт зохион байгуулагдаж 3 /Иххэт, Сайхандулаан, Дэлгэрэх/ сумдын хоршоодын төлөөлөл 6 гишүүнийг хамруулсан. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулалтад хамрагдсан иргэн аж ахуй нэгжээс "Гэрэлт шанд" ХХК нь хиам үйлдвэрлэлээ өргөжүүлж шинээр талх, хэрчсэн гурил, бууз банш үйлдвэрлэхээр тоног төхөөрөмж худалдан авах төсөл хэрэгжүүлж 200,0 сая төгрөгийн санхүүжилтэд хамруулсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн "Старт-ап" арга хэмжээг "Хөгжлийн шийдэл" ТББ, "Вэст метод" ХХК-ны дэргэдэх Бэст инноваци бизнес хөгжлийг дэмжих сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулж 6 багийг дэмжин ажиллах бэлтгэл ажлыг хангасан. Аймгийн Политехникийн коллежид хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн ангийг 7, гадна оёдолчин 18, үсчин 21, гоо сайханч 2, хэвлэлийн графикч 17, бэлэг дурсгалын зүйл урлаач 9, тогооч 35, худалдагч 6, нийт 84 мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн. Орон нутагт хэрэгжиж буй "Гамшигт тэсвэртэй орон нутаг", "Монгол ногоо" төслийн хүрээнд газар тариалан эрхлэгч болон малчдын төлөөллийг малын тэжээл тариалах сургалт болон Төв аймагт газар дээр нь туршлага судлуулах дадлага сургалтад тус тус хамруулсан.	90%
3.4. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгож буй урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;						
13		3.4.1. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бие	2019 - 2022		10 их наядын хөтөлбөр ажлын байр дэмжих зээлийг арилжааны банкаар дамжуулан 38,8 сая төгрөгийн зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 56 иргэнийг хамруулан 238,0 сая	100%

	даасан, бүтээлч байдлыг дэмжиж, өрсөлдөх чадварыг сайжруулан шинэ ажлын байр бий болгоно.			төгрөгийн дэмжлэг, жижиг зээлд 2 иргэнийг хамруулан 20,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, нийт 58 байнгын шинэ ажлын байр бий болгосон. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу 2019-2022 онд 20 төсөлд 1,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгон 56 ажлын байр, сум хөгжүүлэх болон хоршоо хөгжүүлэх сангаас 182 төсөлд 7,9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгон 156 ажлын байрыг тус тус шинээр бий болгосон.	
14	3.4.2. Орон нутгийн засаг захиргаа брэнд бүтээгдэхүүн бий болгох хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжиж, санхүүгийн болон санхүүгийн бус аргаар дэмжинэ.	2019 - 2022		<p>Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, бий болгох ажлын хүрээнд "Нэг суурин - Нэг бахархал" аяныг өрнүүлж, 2 удаагийн сургалтад 76 үйлдвэрлэгчийн төлөөлөл 116 хүнийг хамруулсан. Орон нутгийн онцлогийг тусгасан гар урлалын багц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулдаг Мондо урлан ХХК-ийн бараа бүтээгдэхүүнийг аймгийн брэнд бүтээгдэхүүнээр төлөөлүүлэн Жижиг дунд үйлдвэрийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, "Alibaba ЖиДиТи Монгол" институтээс "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн 2022" аяны хүрээнд зохион байгуулагдсан шалгаруулалтад материалыг явуулсан.</p> <p>Олон нийтэд чиглэсэн сурталчилгааг үзэсгэлэн худалдаа, нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг арга хэмжээний хүрээнд 2500 гаруй иргэд, аж ахуйн нэгжид хүргэсэн. Органик хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгийг 9 сум 28 иргэн аж ахуйн нэгжид 408,6 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 225 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон, цагаан идээ, жимс жимсгэнэ, цай, 7 төрлийн даршилсан ногооны бүтээгдэхүүн шинээр туршин экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлсэн.</p>	100%
15	3.4.3. Барааны тэмдэг, газарзүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулна.	2019 - 2022		<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/142 дугаар захирамжаар "Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэл" батлан, орон нутгийн түүхий эдийн нөөц боломж, давуу талд тулгуурласан өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжин зээл олгох чиглэл барин ажилласан. "Далт Мөнгөн Шанд" ХХК нь ЖДҮ-ийг дэмжих сангаас 81,8 сая төгрөгийн зээлийг авч орон нутагт нэрийн дэлгүүр ажиллуулахаас гадна Улаанбаатар хотод нэрийн дэлгүүр буюу Загсгал зоогийн газарт үйлдвэрийн үнээр борлуулахаас гадна, загсгалтай бүтээгдэхүүнээр үйлчилж, загсгалын шүүсээр базсан хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах, Улаанбаатар хотын Номин, Сансар, E-Mart, Оргил сүлжээ дэлгүүрүүд, Хурд, Тэнгэр плаза, Дүүхээ төв, Нарантуул захын өргөтгөл, Бөмбөгөр худалдааны төв зэрэг томоохон 90 салбар дэлгүүрээр худалдаалсан.</p> <p>"Оюу-Шанд" ХХК нь ЖДҮ-ийг дэмжих сангаас 25,0 сая төгрөгийг зээлийг авч</p>	100%

					2021 оноос эхлэн өөрийн үйлдвэрлэлийн боловсруулах цехийг байгуулан хулуугаар хийсэн Зээг варень зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг технологийн дагуу чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн Айраг, Даланжаргалан, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд сумын нийт 25 цэгт борлуулалтыг хийж эхэлсэн.	
16	3.4.4. Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэл дэмжих замаар ажлын байр бий болгон сумандаа сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.	2019 - 2022			Сум орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд 2019-2022 онд Сум хөгжүүлэх сан болон Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг 91 төсөлд 1,2 тэрбум төгрөг, ЖДҮХС-аас 20 төсөлд 1,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож дэмжлэг үзүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт Айраг сум 5 иргэн, Даланжаргалан 2 иргэн, Замын-Үүд 5 иргэн, Улаанбадрах 1 иргэн, Хатанбулаг 3 иргэн, Алтанширээ 3, Эрдэнэ 5, Сайхандулаан 3, Дэлгэрэх 1, Өргөн 2, Сайншанд 26 иргэн, нийт 11 сумын 56 иргэнийг хамруулан, нийт 238.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж өрхийн амьжиргаагаа дээшлүүлсэн. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 189 иргэн, аж ахуй нэгж 13,4 сая, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 261 иргэн, 12 аж ахуй нэгж нийт 497,3 сая, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа 9 иргэн, аж ахуйн нэгж 545,0 сая, тээвэр, агуулахын үйл ажиллагаа 6 иргэн, аж ахуй нэгж 634,0 сая, цахилгаан, хий, уур, агааржуулалт 1 иргэн, аж ахуйн нэгж 160,0 сая, уул уурхай, олборлолт 1 иргэн 500,0 сая, хөдөө аж ахуй 542 иргэн, аж ахуйн нэгж 889,2 сая төгрөг Засгийн газраас 3 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг улс орон даяар 2022 оны 4 дүгээр сараас олгож эхэлсэн ба тус зээлд Хүнсний ногооны чиглэлээр 4 иргэн, 1 хоршоонд 69.6 сая төгрөгийн зээл арилжааны банкаар дамжин олгогдсон.	90%
17	3.4.5. Урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн эрсдэлийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох байгууллагатай хамтран батлан	2019 - 2022			Сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг зориулалтын дагуу зарцуулах сум орон нутагт нэн шаардлагатай үйлдвэр үйлчилгээг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд аймгийн хэмжээнд 52 төсөлд 739,0 сая төгрөг, “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2019-2020 онд 25 иргэнд 238.0 сая төгрөгийн жижиг зээлийг олгосон бөгөөд тэдгээрийн эргэн төлөлтөөс 2021 оны 10 дугаар сарын байдлаар 105.0 сая төгрөг хуримтлагдсаныг бичил, жижиг бизнес эрхлэгчдэд олгохоор төлөвлөн арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх зар мэдээг нийт 2 удаа мэдээллийн сайт, фэйсбүүк хаяг, орон нутгийн телевиз, радиогоор иргэдэд хүргэж, 42 иргэн бүртгүүлснээс зээлийн өмнөх сургалтыг 2 удаа зохион байгуулж 40 иргэнийг хамруулсан. Зээлийн өмнөх сургалтад хамрагдсан бичил бизнес эрхлэгч 4 иргэний 40.0 сая	100%



		даалтад хамруулна.			төгрөгийн төслийг хүлээн авч, Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсэг 1 удаа хуралдаж, бичил бизнес эрхлэгч 3 иргэний 15.0 сая төгрөгийн төслийг судлуулахаар Хаан банкны салбар тооцооны төвд хүргүүлснээс 2 бизнес эрхлэгч иргэнд 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	
18		3.4.6. Жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах, нэгдэх санал санаачилгыг нэн тэргүүнд дэмжинэ.	2019 - 2022		Хөдөө аж ахуйн салбарыг кластераар хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан, ажлын төлөвлөгөө боловсруулан түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл явуулах загвар хоршоо бий болгох чиглэл барин 5 сумын Малчдын болон тариаланчдын зөвлөгөөнд “Загвар хоршоо гэж юу вэ, хоршихын ач тус” зэрэг сэдвээр 700 гаруй иргэнд мэдээлэл хүргэн ажилласан. Алтанширээ сумын “Олон ширээ” хоршоо нь загвар хоршоо болохоор гишүүдийн тоогоо нэмж 107 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн, мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх чиглэлээр 2022 онд “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 80.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч шинээр 2 ажлын байр бий болгож, хоршооны гишүүдийн амьжиргаа орлогыг дээшлүүлэн тогтвортой үйл ажиллагаа явуулсан. Тус хоршоо нь тогтвортой ноос ноолуурын холбооны гэрчилгээ авч хоршооны гишүүдийн бэлтгэсэн 40 тн ноолуурыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Гоёл” үндэсний үйлдвэрт нийлүүлэхийн зэрэгцээ ангилан ялгасан түүхий эд бэлтгэн нийлүүлснээр Төв лабораторийн гэрчилгээ авсан.	100%
3.5. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийг өргөтгөх, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн борлуулалтын сүлжээг бий болгох						
19		3.5.1. Бараа, бүтээгдэхүүний шууд борлуулалтын цэгийн тоог нэмэгдүүлнэ.	2019 - 2022		Орон нутгийн бараа ажил үйлчилгээг сурталчлах, зах зээлийг өргөтгөх зорилгоор 2019 онд аймгийн брэнд бүтээгдэхүүн, өрхийн үйлдвэр эрхлэгчдийн гар урлал, бэлэг дурсгал гэх мэт олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалах зорилгоор “Дорноговьд үйлдвэрлэв” төвийг 3-р багт нээсэн. Мөн “Далт мөнгөн шанд” ХХК нь ЖДҮ-ийг дэмжих сангаас зээл авснаар “Загсгал цай” брэндийн нэрийн дэлгүүрийг 2021 онд ашиглалтад оруулсан ба Улаанбаатар хотын “Сансар” худалдааны төвийн 1, “Номин Их дэлгүүр”-ийн 57 салбар, “Оргил” худалдааны төвийн 11 салбар, “Е март” худалдааны төвийн 3 салбар, өөрийн аймгийн 14 сумын 21 цэг, нийт 90 салбар цэгт борлуулалт хийж үйл ажиллагаа нь өргөжсөн. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас хөнгөлөлттэй зээл авсан “Оюу шанд” ХХК нь хурган гуа, хүрэн манжингийн “Зээг варень”-ны цех байгуулан үйлдвэрлэл явуулж, 6 сумын 25 цэгт, “Гэрэлт шанд” ХХК нь өөрийн нэрийн дэлгүүр, 14 сумын 23 цэгт 7 нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн, “Цагаан сүүний буян” ХХК нь өөрийн нэрийн борлуулалтын цэг, “Эргэл”, “Номин”, “Наран”, “Мөнхдүүрэн” хүнсний захын лангуугаар сүү, сүүн бүтээгдэхүүнийг тус тус борлуулж байна. Орон нутгийн газар тариалан эрхлэгчдийг дэмжин 2022 оны 9 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 15-ныг дуустал төмс, хүнсний ногоо	100%

					борлуулах 9 цэгийг ажиллуулснаар борлуулалтын орлого нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.	
20	3.5.2. Бараа бүтээгдэхүүний борлуулах маркетинг болон сурталчилгаа хийх мэдлэг, мэдээлэл олгоно.	2019 - 2022			<p>Монголын худалдагч нарын холбоотой хамтран "Мөнх дүүрэн", "Эргэл" "Алтанговь" зэрэг 3 захын худалдагч нарт барааны чанар стандарт, бараа хадгалалт, өрөлт, хураалтын үндсэн шаардлагын талаар сургалт зохион байгуулж 100 гаруй худалдагч нарыг, Хөгжлийн шийдэл ТББ-ын "Best" хөтөлбөртэй хамтран Сайншанд сумын "Худалдаа, хоол үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэр, ахуй үйлчилгээний салбарын ажилтныг чадавхжуулах" сургалтыг зохион байгуулж "Үйлчилгээний стандарт, ур чадвар харилцаа хандлага", "Ажил олгогчийн урамшуулал, төсөл хөтөлбөр" сэдвийн хүрээнд мэдээлэл хүргэж 53 иргэнийг тус тус хамруулсан. ХХҮГ-ын төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг дэмжих, бүтээгдэхүүнийг танилцуулах, сурталчлах зорилгоор 13 иргэний үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг байгууллагын вэб сайт болон пэйж хуудсаар, 15 иргэний үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг орон нутгийн DTV телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэж цувралаар хүргэж ажилласан.</p> <p>"Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран Мандах, Даланжаргалан, Замын-Үүд сумдад "Санхүү татварын тайлангийн бүрдэл анхаарах зүйлс", "Бизнес төсөл төлөвлөгөө хэрхэн боловсруулах", "Хөтөлбөрийн оролцогч талуудын уулзалт", "Албан ба албан бус бизнесийн ялгаа сургалт", "Бизнес загвар гэж юу вэ?", "Компанийн засаглалын тухай ойлгол", "Дотоод хяналтын ач холбогдол" "Цар тахлын үед бизнес загвараа тодорхойлох нь" "Бизнесийн эрсдэлийн удирдлага ба дотоод хяналт" уулзалт, "Сошиал медиа ба бизнесийн боломжууд" сэдвээр сургалт хэлэлцүүлэг зохион байгуулан 3 сумын давхардсан тоогоор 256 иргэн, ААН-ийг хамруулсан. Гадаад харилцааны яам, НҮБ-тай хамтран "Бизнесийн салбарт хүний эрхийг хангах нь" Говийн болон зүүн бүсийн хэлэлцүүлэг 2021 оны 11 сарын 11,12 -ны өдрүүдэд зохион байгуулж 8 аймаг 160 гаруй Төрийн болон ТББ, Бизнес эрхлэгч 80 хүн танхимаар, 80 гаруй хүн цахимаар оролцсон.</p>	100%
21	3.5.3. Дотоодын болон олон улсын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах, олон улсын үзэсгэлэн худалдаа, бизнес уулзалтад орон нутгийн бизнес эрхлэгчдийг	2019 - 2022			<p>Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн буйр аймагт зохион байгуулагдсан "Ногоон хөгжил" олон улсын үзэсгэлэн яармагт 5 хүний төлөөллийг хамруулж шинэ техник, технологи, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулж хамтын түншлэлээ бэхжүүлэн ажилласан. Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулдаг "Бурхантын цагаан идээ" хоршоо Шилийн гол аймаг, Рашаан аймаг, Шилийн гол аймгийн Зүүн сүмд хошуу, Баруун үзэмчин хошуу, Тунлиу хотуудад нийтдээ 6 удаагийн үзэсгэлэн яармагт сүү, сүүн бүтээгдэхүүн, цагаан идээний төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 1 удаагийн үзэсгэлэнд ойролцоогоор 15000-20000 юань-аар борлуулалтын орлогоо нэмэгдүүлсэн.</p> <p>Монгол Улсад хоршооллын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан</p>	100%

		оролцоход дэмжлэг үзүүлнэ.			Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооноос хэрэгжүүлж буй “Хоршоонд суурилсан хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төсөлтэй хамтран дотоодын туршлага судлах, үзүүлэх сургалтад Алтанширээ сумын “Олон ширээ”, Даланжаргалан сумын “Боржигон туяа”, Сайншанд сумын “Мөнх-Ашиг” хоршоодын төлөөлөл хамрагдаж туршлага судалсан. Орон нутгийн хүнс, газар тариалан, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.	
3.6. Байгальд ээлтэй техник, технологийг эрчимтэй нэвтрүүлэн, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах;						
22		3.6.1. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа шинжилгээний ажлыг салбарын бодлоготой уялдуулна.	2019 - 2022		<p>Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран Дэлгэрэх сумын нутгийн улаан ямааг омгоор баталгаажуулах судалгаа шинжилгээний ажлыг 2010 оноос эхлүүлж “Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох хяналт тавих журам”-д заасны дагуу хэлэлцүүлж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-61 дүгээр тушаалаар бие даасан “Дэлгэрэхийн улаан” омгоор баталгаажуулсан. Дарханы Улсын газар тариалан судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран сорт сорилт, хөрсний шинжилгээ хийлгэх, холбогдох сургалт зөвлөмжийг авч хамтран ажилласан. Дорноговийн хонины мах хөтөлбөрийн хүрээнд 2020-2022 онд Улаанбадрах, Хөвсгөл, Өргөн, Эрдэнэ сумд, Архангай аймгийн Ихтамир сумдад бэлчээрийн ургамалд давхардсан тоогоор 52 овог, 86 төрөл, 94 зүйлийн ургамал, хонины маханд 16 төрлийн шинжилгээ, судалгааг хийсэн. 2022 онд шинээр Солонгосын бууцай, байцаа, салат навчны гурван төрлийн сортыг тариалан туршихаар сумдад үрийг хуваарилсан.</p> <p>Сорт сорилтын ажлын хүрээнд тарвас, амтат гуаны 2, эртийн байцайны 1, сонгино 1, тарвасын 1, саримс 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн.</p>	100%
23		3.6.2. Олон улсын стандартыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ техник,	2019 - 2022		<p>Жижиг дунд үйлдвэрийн сангаас үйлдвэр үйлчилгээгээ өргөжүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр 3 иргэнд 237,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй урт хугацаатай, хүүгүй зээлд 1 иргэнийг хамруулж 32 м2 зуны хүлэмжийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдсан. Хүлэмжийн нийлэг хальсан уутыг 3 сумын 5 тариаланчид 5 ширхэгийг олгосон.</p> <p>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 сумын 13 аж ахуйн нэгж, байгууллагын төсөлд 4 шатны үнэлгээ явагдаж 4 аж ахуйн нэгж байгууллагад</p>	100%

		технологи нутагшуулна.			/сүү,сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 2, хүнсний ногоо зоорь, агуулах чиглэлээр 1, оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр 1/ 500,0 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэнээр 16 ажлын байр шинээр бий болох боломжтой болсон.	
24		3.6.3. Орон нутгийн өрхийн болон жижиг, дунд үйлдвэрт зориулсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах арга хэмжээ зохион байгуулна.	2019 - 2022		Япон улсын зах зээлд "Монголын үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ"-г танилцуулах цахим форумд "Хамарын хийд", үндэсний тохирлын тэмдэгтэй нутгийн брэнд "Загсгал цай"-г сурталчлан оролцсон. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг жижиг, дунд үйлдвэрийн газар "Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого", "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-т тусгагдсан Нэг суурин - Нэг бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021 оны 07 сарын 20-нд "Орон нутгийн-Онцлох бүтээгдэхүүн"-ийг цувралаар аймгийн "Тарвас", "Загсгал цай", "Тансаг цагаан ингэний хоормог"-ийг онцлон танилцуулгад оруулсан. Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдааг зохион байгуулан, 14 сумын 358 гаруй иргэн, аж ахуй нэгж, хоршоо, нөхөрлөл оролцож бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан 187,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн аяны хүрээнд 14 сумдаас "Брэнд" бүтээгдэхүүнийг шалгаруулан орон нутгийн телевиз, байгууллагын цахим хуудсаар дамжуулан цувралаар танилцуулж олон нийтэд сурталчлан ажилласан.	100%
25		3.6.4. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжинэ.	2019 - 2022		Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгон үйл ажиллагааг нь дэмжин хамтран ажиллах зорилгоор шинээр үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд гарааны бизнесийг дэмжиж Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын бичил зээл, Итгэлийн зээл гэх мэт төсөл хөтөлбөр, мөн жижиг дунд үйлдвэрийн сангийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг банкны шалгуур хангасан 6 иргэн, аж ахуй нэгжид 545,0 сая төгрөгийн зээлийг олгосон. Сумдын тэргүүлэх чиглэл болоод Засаг даргын мөрийн хөтөлбөрийн дагуу сум хөгжүүлэх сангийн зээлийг үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдэд нийт 52 иргэнд 793,0 сая төгрөг, "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн гарааны бизнесийг дэмжих "Старт-ап" арга хэмжээнд 5.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. "Оюу шанд" ХХК нь Жижиг, дунд үйлдвэрийн сангаас 25,0 төгрөгийн зээл авч Сайншанд суманд бага оврын цех байгуулан хурган гуа, хүрэн манжингийн "Зээг варень" бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн 6 суманд 25 цэгт борлуулж эхэлсэн. Хөгжлийн шийдэл ТББ-ын зорилт-5 буюу цаашид тогтвортой хөгжих боломжтой, санхүүжилт авах чадамжгүй төрийн бус байгууллага, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд санхүүжилт олгох зорилтын хүрээнд 2021, 2022 онд Дорноговь аймагт 8 гарааны бизнес эрхлэгчид тус бүр 10,0 сая төгрөг буюу 80,0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгож шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гарааны	100%

					бизнесийг дэмжиж ажилласан.	
26		3.6.5.Мэргэжлийн байгууллагатай хамтран орон нутгийн үндэсний чанарын тэмдэгтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.	2019 - 2022		“ДАЛТ МӨНГӨН ШАНД”- ХХК нь 2013 оны 07 дугаар сард Үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх гэрчилгээг авсан. "Оюу шанд" ХХК нь Хурган гуа-хүрэн манжингийн "ЗЭЭГ" варениа үндэсний чанарын тэмдэгтэй бүтээгдэхүүн болгохоор холбогдох бэлтгэл ажлыг зохион байгуулсан.	0%
<b>ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>						<b>93.46%</b>

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:  
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХӨНГӨН, ХОРШОО,  
АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.БУДЦЭЦЭГ